

БАЙР СУУРЬ

МОНГОЛ УЛСЫН САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД СЭНДБОКСЫН ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИНГ АМЖИЛТТАЙ НЭВТРҮҮЛЖ БАЙНА

Энэ удаагийн ярилцлагаар сэндбокс зохицуулалтын орчин болон виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга, Сэндбоксын зөвлөлийн дарга Н.Хүдэрчулуунтай ярилцлаа.

Өмнөх нь 1-р нүүрт



Манай улсын хувьд технологид суурилсан санхүүгийн үйлчилгээ эрхэлж буй байгууллагуудыг бүртгэх, үйл ажиллагааны зөвшөөрөл олгох, зохицуулж хянах, шинэ төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээ зах зээлд нэвтэрснээр үүсэж болох эрсдэлээс үйлчлүүлэгч, хөрөнгө оруулагчдыг хамгаалах зорилгоор “Сэндбокс зохицуулалтын орчны журам”-ыг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөр 2021 онд баталсан.

Сэндбоксын зохицуулалтын орчин олон улсад хэрхэн зохицуулагдаж байгаа бэ?

Сэндбокс зохицуулалтыг хамгийн анх 2016 онд Их Британи Улс шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргахад зарцуулах цаг хугацаа, зардлыг бууруулах, зах зээлд нэвтэрч буй бүтээгдэхүүний тоог нэмэгдүүлэх, технологид суурилсан шинэлэг бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрэхээс өмнө турших зорилгоор санхүүгийн зах зээлд нэвтрүүлсэн. Үүний дараагаар Сингапур Улс мөн тус онд Сэндбокс зохицуулалтын орчныг Төв банкны хяналт, зохицуулалтын дор бүрдүүлсэн бөгөөд өнөөдрийн байдлаар шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ тус бүрийн онцлогт тохирсон сэндбокс, сэндбокс экспресс, сэндбокс плас зэрэг 3 төрлийн сэндбокс зохицуулалтыг хэрэгжүүлж байна.

Хэдийгээр Англи, Сингапур зэрэг өндөр хөгжилтэй улс орнууд сэндбокс зохицуулалтын орчныг бий болгоход анхдагчид байсан хэдий ч Бразил, Болгар, Мексик, Гүрж, Унгар, Энэтхэг гэх зэргээр хөгжиж буй эдийн засагтай улс орнууд мөн тус зохицуулалтын арга хэрэгслийг хурдацтайгаар нэвтрүүлж байна.

Дэлхийн банкны 2020 оны 11 дүгээр сарын Сэндбоксын зохицуулалтын орчны олон улсын туршлага судалгаанд дурдсанаар тус аргачлалыг 57 улс хэрэгжүүлж буй бөгөөд эдгээрийн 16 улс нь өндөр хөгжилтэй орон байгаа бол 41 улс нь хөгжиж буй орон байна. Уг судалгаанд сэндбоксын зохицуулалтыг бодлогод суурилсан, инновац болон бүтээгдэхүүнд суурилсан, нарийн зохицуулалт шаардагдах бүтээгдэхүүнд суурилсан, хил дамнасан санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг зохицуулах зориулалттай гэж дөрвөн төрөлд ангилсан.

Түүнчлэн 2022 оны 07 дугаар сард Испанийн Засгийн газар болон Европын Комисс Брюссельд болсон арга хэмжээний үеэр хиймэл оюун ухааны (AI) анхны сэндбокс зохицуулалтын орчны туршилтыг танилцуулсан нь сэндбоксын зохицуулалтын орчин богино хугацаанд хурдацтай хөгжиж буйг илэрхийлж байгаа болов уу.

Сэндбокс зохицуулалтын орчны журам хэрэгжиж эхлээд жил гаруй хугацаа өнгөрсөн байна. Энэ хугацаанд ямар ажлууд хийгдсэн вэ?

“Сэндбокс зохицуулалтын орчны журам” нь 2021 оноос хэрэгжиж эхэлсэн. Тус журамд зааснаар сэндбоксод орох хүсэлтийг гурав болон есдүгээр саруудын ажлын эхний 10 хоногийн хугацаанд хүлээн авдаг ба журам батлагдаж хэрэгжсэн үеэс өнөөдрийг хүртэлх хугацаанд нийт 12 байгууллага сэндбоксын орчинд орох хүсэлт ирүүлснийг хянан шаардлага хангаагүй 6 хүсэлтийг буцааж, нэр бүхий 4 байгууллагын системд газар дээрх үзлэг хийсэн. Одоогийн байдлаар Мобифинанс ББСБ ХХК-ны нээлттэй цахим өрийн хэрэгсэл буюу Монпэй дижитал бонд, Мони маркет фанд ХХК-ны Монимаркет вэб системээр дамжуулан репо хэлцлийн хүсэлт гаргах, хэлцлийн дагуу худалдах, худалдан авах ажиллагааг бүртгэх үйлчилгээ нь Сэндбоксын орчин амжилттай нэвтрэн үйл ажиллагаагаа явуулж байна. Эдгээр санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ нь хоёул зах зээлд шинэлэг бүтээгдэхүүн бөгөөд амжилттай туршигдсан тохиолдолд бүтээгдэхүүний онцлогт тохирсон эрхзүйн орчныг бий болгох шаардлага үүсэх юм.

Санхүүгийн зохицуулах хорооны хувьд санхүүгийн компаниудыг сэндбоксын орчинд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ бодитоор турших боломжийг бүрдүүлэх, амжилттай туршигдсан бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэхэд шаардагдах эрх зүйн зохицуулалтыг бий болгох чиглэлд голлон анхаарч, шаардлагатай судалгааг гүйцэтгэн, холбогдох төрийн байгууллагууд болон сэндбоксод оролцогч компаниудтай хамтран ажиллаж байна.

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль 2021 оны 12 сард батлагдсан. Санхүүгийн зохицуулах хорооноос хуулийн хэрэгжилтийг хангахтай холбоотой ямар ажлыг хийж гүйцэтгээд байна вэ?

Монгол Улсад виртуал хөрөнгөтэй холбоотой үйл ажиллагааг эрхлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах, тэдгээрийг үүсэж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний тогтолцоог бэхжүүлэх бодлогын хүрээнд Монгол Улсын Их Хурлаас 2021 онд Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийг баталж, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль болон бусад нэр бүхий 12 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Эдгээр хуулиуд энэ оны 2 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Түүнчлэн хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хуульд тусгайлан 2 харилцаанд хамаарах шилжилтийн үеийн зохицуулалтуудыг тусгасан.

Нэгт, хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш дөрвөн сарын хугацаанд Хороо аливаа этгээдийг Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр бүртгэхгүй ба энэ хугацаанд Хорооноос виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн бүртгэл, засаглал, үйл ажиллагаанд тавигдах шаардлага, мөн тохиромжтой этгээдийг тодорхойлох, хяналт шалгалт хийх зэрэг 10 орчим харилцааг зохицуулсан 8 журмыг боловсруулж, олон нийт, мэргэжлийн байгууллагын саналыг авч, хэлэлцүүлэн баталсан. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн дагуу Хороо 2022 оны 6 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэх компанийн хүсэлтийг хүлээн авч эхэлсэн.

Хоёрт, хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс өмнө виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлж байсан этгээдүүд шилжилтийн үеийн зохицуулалтын дагуу буюу 2022 оны 06 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн 3 сарын хугацаанд хууль, журмын шаардлагыг ханган виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр Хороонд бүртгүүлэх үүрэгтэй байхаар хуульд зохицуулсан. Иймээс 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрөөс өмнө энэ төрлийн үйл ажиллагаа эрхлэгчид 2022 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн дотор амжиж бүртгэлээ заавал хийлгэсэн байх шаардлагатай. Хэрэв хуулиар заасан энэ үүргээ биелүүлэхгүй, бүртгэл хийлгэж амжаагүй бол тухайн компани 2022 оны 09 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн үйл ажиллагаагаа бүрэн зогсоох шаардлага үүснэ. Үйл ажиллагаагаа зогсоохгүйгээр виртуал хөрөнгийн үйлчилгээг бүртгэлгүйгээр эрхлэх тохиолдолд Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээх нөхцөл үүсэхээр байгаа юм. Одоогийн байдлаар албан ёсоор бүртгэгдсэн компани байхгүй боловч 8 компани бүртгэл хийлгэхээр хүсэлтээ ирүүлснийг хууль, журмын шаардлага хангаж байгаа эсэхийг тогтоохоор ажиллаж байна.

Өмнө виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлж байсан компани хуулийн хугацаанд хүсэлт гаргаагүй, эсвэл хууль, журмын шаардлага хангаагүйгээс таны хэлсэн хугацаанд бүртгүүлэггүй бол тухайн компанийн үйл ажиллагаа зогсоох шаардлагатай юу?

Тийм. Хуульд 5 төрлийн үйл ажиллагааг виртуал хөрөнгийн үйлчилгээнд хамааруулна гэж тусгасан бөгөөд тухайн үйлчилгээг эрхлэхээр бүртгүүлээгүй этгээд виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэхийг хориглосон. Хэрэв виртуал хөрөнгийн үйлчилгээг бүртгэлгүйгээр эрхлэх тохиолдолд Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэх зохицуулалттай.

Иймээс миний сая дурдсан 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрөөс өмнө энэ төрлийн үйл ажиллагаа явуулж байсан этгээдүүд 2022 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн дотор хуулиар заасан үүргээ биелүүлэхгүй, бүртгэл хийлгэж амжаагүй бол тухайн компани 2022 оны 9 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн үйл ажиллагаагаа бүрэн зогсоох шаардлагатай болно. Харин үйл ажиллагаагаа зогсоохгүйгээр виртуал хөрөнгийн үйлчилгээг үргэлжлүүлбэл мөн адил Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээх нөхцөл үүсэхээр байгаа.

Тэгвэл 2022.09.27-ны өдрөөс эхлэн үйл ажиллагаагаа зогсоосон компанийн хувьд өмнө гэрээ байгуулсан харилцагч болон арилжаалж байсан койн, токен дээр ямар арга хэмжээ авах шаардлагатай вэ?

Тус хууль нь виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэх компанид тавигдах шаардлага, үүргийг тодорхойлох, тэдгээрийг бүртгэх, үйл ажиллагаанд нь хяналт тавихтай холбогдох харилцааг зохицуулахаар байгаа. Харин виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч болон харилцагчийн хооронд бий болсон гэрээ, хэлцлээс үүсэх маргаан, түүнчлэн виртуал хөрөнгө болон түүний зах зээлтэй холбоотой харилцаанд шууд хамаарахгүй гэдгийг ойлгох хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, холбогдох шаардлага хангасан компани Хороонд бүртгүүлнэ, бүртгэгдсэн тухайн компани нь Хороогоор хянагдаж, зөвшөөрөгдөн батлагдсан виртуал хөрөнгийг арилжихтай холбоотой харилцааг зохицуулсан өөрсдийн бодлогын баримт бичиг, журамдаа нийцсэн шинэ виртуал хөрөнгийн арилжааг платформ дээрээ нэмэх, арилжих эсэхээ өөрөө шийдэх юм.

Тэгэхээр 2022 оны 9 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн үйл ажиллагаагаа зогсоосон компанийн хувьд цаашид үйл ажиллагаа явуулах боломжгүй болж байгаа учир өөрсдийн платформд арилжиж, хадгалж байсан харилцагчдын виртуал хөрөнгийг тухайн харилцагчтай, мөн Хороонд албан ёсоор бүртгэгдсэн виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчтэй тохиролцож зөвшилцсөний үндсэн дээр тэдгээрийн арилжааны платформ руу шилжүүлэх боломжтой. Мэдээж тухайн харилцагчийн эзэмшдэг виртуал хөрөнгө нь гадаад улсын өөр виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн арилжааны платформд арилжигддаг бол тэдгээрийн арилжааны платформ руу, эсхүл өөрсдийн тухайн койн, токеныг үүсгэсэн блокчэйн дэх хувийн данс руу хөрөнгөө шилжүүлэх хувилбар ч байж болно.

Мөн Хорооны хувьд Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль, дагаж гарсан бусад хууль, баталсан захиргааны хэм хэмжээний актуудын хэрэгжилтийг хангах, хяналт тавих чиг үүрэгтэй учир хууль хүчин төгөлдөр болохоос өмнө бий болсон харилцаанаас үүсэлтэй эдгээр асуудалд шууд оролцох, зохицуулалт хийх бүрэн эрхгүй байдаг. Хэдийгээр ийм бүрэн эрх, чиг үүрэг олгогдоогүй ч хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах хүрээнд Хорооноос хууль батлагдахаас өмнө виртуал хөрөнгө, виртуал хөрөнгийн үйлчилгээтэй холбоотой бий болж болох эрсдэлүүдийг олон нийт, иргэдэд хандан хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаар тухай бүр анхааруулга, сэрэмжлүүлэг хүргэж ажилласан.